

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ ШИЛЖҮҮЛЭХ, СЭЛГЭН АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ ЗАР

Нийтлэгдсэн огноо: 2026-03-31

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдыг дараах албан тушаалд холбогдох материалаа ирүүлэхийг урьж байна.

Тухайн байгууллагад болон холбогдох бусад төрийн байгууллагын адил ангиллын албан тушаалд ажиллаж байгаа, албан тушаалын тодорхойлолт, холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан, уг албан тушаалд шилжин ажиллах хүсэл сонирхолтой төрийн жинхэнэ албан хаагчдаас тухайн орон тоо нөхөгдөөгүй тохиолдолд Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.2 дахь заалт, 33.3 дахь хэсэгт заасны дагуу тусгай шалгалтыг холбогдох журмын дагуу зохион байгуулна.

Тавигдах, болзол шаардлага:

- Төрийн жинхэнэ албан тушаалд зохих ёсоор томилогдсон байх;
- Зарлагдсан албан тушаалтай адил төрөл болон адил ангилалд ажилладаг байх;
- Зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх.

Бүрдүүлэх материал:

- Төрийн албан хаагчийн анкет;
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/, хэрэв гадаад улсад их,дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
- Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичиг;
- Нийгмийн даатгалын дэвтэр /Хөдөлмөрийн дэвтэр/-ийн хуулбар, цахим лавлагаа;
- Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;
- Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн “Тангаргийн хуудас” хуулбар;
- Сүүлийн гурван жилийн төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн илтгэх хуудас, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ;
- Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт /e-mongolia-аас татан авах/.
- Материалуудыг дарааллын дагуу эмх цэгцтэй ирүүлэх.

Материал хүлээн авах:

- Хугацаа: 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөс 2026 оны 04 дугаар сарын 06-ны өдрийн 17:30 цаг хүртэл
- Хүлээн авах хаяг: norjmaa.d@khurdan.gov.mn
- Холбоо барих утас: 260308 /гар утаснаас залгах бол 51260308 ажлын цагаар/

Шилжүүлэх, сэлгэн авах ажлын байрны жагсаалт

| № | Байгууллага | Дотоод нэгж | Албан тушаал | Орон тоо | Албан тушаалын | | Албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлага | | | |
|---|---|---------------------------|---|----------|-----------------------------|----------------------|---|---|---|---|
| | | | | | төрөл | Ангилал, зэрэглэл | Боловсрол | Мэргэжил | Мэргэшил | Туршлага |
| 1 | Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар | Захиргаа удирдлагын газар | Захиргаа удирдлагын газрын дарга | 1 | Төрийн захиргааны удирдах | Эрхэлсэн түшмэл ТЗ-3 | Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх | Мэдээлэл харилцаа холбооны технологиуд, менежмент ба удирдахуй, эрх зүй, эдийн засаг. | Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан байх. | Төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх. |
| 2 | Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар | Захиргаа удирдлагын газар | Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, тайлан хариуцсан ахлах мэргэжилтэн | 1 | Төрийн захиргааны гүйцэтгэх | Дэс түшмэл ТЗ-6 | Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх | Мэдээлэл харилцаа холбооны технологиуд, менежмент ба удирдахуй, эрх зүй, эдийн засаг. | - | Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно. |

